



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ИХ СУРГУУЛИУДЫН ХОТХОНЫ АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГААНЫ

2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараахь хаягаар харилцана уу:

САГазрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг:  
[naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Оюунгэрэл  
Утас: 261885  
Цахим хаяг:  
[oyungerelts@audit.gov.mn](mailto:oyungerelts@audit.gov.mn)

Аудитор: Д.Цэгмиддорж  
Утас: 261740  
Цахим хаяг:  
[tsegmiddorjd@audit.gov.mn](mailto:tsegmiddorjd@audit.gov.mn)

[Монгол Улсын](#)  
[Үндэсний аудитын газар:](#)  
Засгийн газрын IY байр  
Улаанбаатар-15160  
Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг  
Вэб хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

[“Мэдээлэл-Аудит” ХХК](#)  
БГД, 18-р хороо,  
Sky apartment, 4 давхар, 19 тоом  
Захирал: Д.Товуудорж  
Утас:70159511  
Вэб хуудас:  
[medeeleaudit@gmail.com](mailto:medeeleaudit@gmail.com)

# Аудитын тайлан

## АГУУЛГА

---

*Хавсралт 1: Аудитын гэрчилгээ*

*Хавсралт 2: Аудитын тайлан*

*Хавсралт 3: Менежментийн захидал*

*Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан*

*Хавсралт 5: Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн  
тайлан*



1	Аудитын гэрчилгээ .....	1
2	Аудитын тайлан.....	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	4
2.5	Дотоод хяналт .....	5
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	5
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	5
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	6
2.9.1	Томилолтын зардлын талаар .....	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	7
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал .....	8
3.1	Томилолтын зардлын талаар.....	9
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	10
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	10
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	14
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	17



## 1 Аудитын гэрчилгээ



### МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/444  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ИХ СУРГУУЛИУДЫН ХОТХОНЫ  
АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ЗАХИРГААНЫ  
ДАРГА Ю.ЭНХБАТ ТАНАА

#### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.




W10.10.10.2018\Bichig\KherelYawsan\_Bichig\2018\0223SAG31.Docx

070411

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 Оршил

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны дарга Ю.Энхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /УАГ-САГ/2018/229/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 23-наас 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн, “Мэдээлэл Аудит” компанийн ахлах аудитор А.Гэрэлмаа удирдсан аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаартай албан бичгээр “Мэдээлэл-Аудит”ХХК-д ирүүлсэн байна.

### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх ажлыг удирдан, зохион байгуулах зорилгоор 2010 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн Монгол улсын Засгийн Газрын 56 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг, 2010 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн Монгол улсын Засгийн Газрын 149 дүгээр тогтоолоор батлагдсан чиглэлийн дагуу үйл ажиллагааг явуулдаг.

Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэн, үндэсний их сургуулиудыг чадавхижуулан сургалт, судалгаа, шинжлэх ухаан, үйлдвэрлэл бизнесийн холбоог бэхжүүлж олон улсад өрсөлдөх чадвартай дээд боловсролын тогтолцоог эх орондоо бий болгон, ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдсэнээр баялагт суурилсан эдийн засгаас мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих үндэс суурийг тавих зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна

### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон

хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 5 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгийн 1 хувиар тооцож 14,333.4 мянган төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Acolous” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

## 2.5 Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалттай байна.

## 2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс 205,183.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөвлөгдсөнөөс 205,183.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс үйл ажиллагааны урсгал зардалд 200,396.3 мянган төгрөг зарцуулж, төсвийн үлдэгдэл 4,787.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн гүйцэтгэл 97,6 хувьтай байна. Төрийн албан хаагчдад олгох 300.0 мянган төгрөгийн тэтгэмжийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалын дагуу сахилгын шийтгэлгүй албан хаагчдад олгосон байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан эсэхэд 2017 оны 11 дүгээр сард нийцлийн аудит хийгдсэн болно. Тайлант онд Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны хувьд цахим санд 16 төрлийн мэдээллийг жил, улирал, сарын давтамжтай, 83 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Томилолтын зардлын талаар

Тайлант хугацаанд төсөвлөгдөөгүй 7,654.2 мянган төгрөгийн гадаад томилолтыг дотоод томилолтын зардлаар тайлагнасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.3.1-д "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хавсралт № 1 "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5.2-д "Төсвийн байгууллага зардлын бүлэг хоорондын зохицуулалтын хүсэлтийг ТЗБ№1 маягтаар бэлтгэн харьяа төрийн санд хүргүүлнэ", 5.5-д "Төсвийн байгууллага журмын 5.1-д заасан бусад төсвийн зохицуулалт хийх саналыг Төсвийн ерөнхийлөн захирагчид хандан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хавсралт № 1 "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5.2-д "Төсвийн байгууллага зардлын бүлэг хоорондын зохицуулалтын хүсэлтийг ТЗБ№1 маягтаар бэлтгэн харьяа төрийн санд хүргүүлнэ", 5.5-д "Төсвийн байгууллага журмын 5.1-д заасан бусад төсвийн зохицуулалт хийх саналыг Төсвийн ерөнхийлөн захирагчид хандан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

### 2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

### 2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД


Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан эрсдэлтэй байж болох Санхүүгийн тайланд Засгийн газрын оруулсан капиталын хэмжээ хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дүнтэй зөрүүтэй байгаад биет тест хийж амжаагүй учир 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгах нь зүйтэй гэж үзэв.

### 2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 7,654.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж 1 зөвлөмж өгсөн болно.

### 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар 1 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.





#### **2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгийн 1 хувиар тооцож 14,333.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

#### **2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

“Мэдээлэл-Аудит”ХХК нь аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



### 3.1 Томилолтын зардлын талаар

### Тэргүүлэх ач холбогдол №2

#### Аудитын ажиглалт

Тайлант хугацаанд төсөвлөгдөөгүй 7,654.2 мянган төгрөгийн гадаад томилолтыг дотоод томилолтын зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.1-д "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хавсралт №1 "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5.2-д "Төсвийн байгууллага зардлын бүлэг хоорондын зохицуулалтын хүсэлтийг ТЗБ№1 маягтаар бэлтгэн харьяа төрийн санд хүргүүлнэ", 5.5-д "Төсвийн байгууллага журмын 5.1-д заасан бусад төсвийн зохицуулалт хийх саналыг Төсвийн ерөнхийлөн захирагчид хандан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

#### Аудитын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлэх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хавсралт №1 "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ыг хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр сарын 05-ны дотор Мэдээлэл-Аудит ХХК-д ирүүлэх;

#### Эрсдэлүүд

Төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх,  
Төсвийн тухай хууль хэрэгжихгүй байх,

#### Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



#### 4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>26,871,335.01</b>	<b>25,761,874.51</b>
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
Төгрөг	0.00	0.00
Төрийн сангийн харилцах	0.00	0.00
<b>АВЛАГА</b>	<b>759,090.00</b>	<b>-</b>
Бусад авлага	759,090.00	-
Байгууллагаас авах авлага	759,090.00	-
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>26,112,245.01</b>	<b>25,761,874.51</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>26,112,245.01</b>	<b>25,761,874.51</b>
Бичиг хэргийн материал	-	224,299.00
Аж ахуйн материал	60,000.00	60,000.00
Түлш шатах тослох материал	1,461,278.01	886,608.51
Бусад хангамжийн материал	24,590,967.00	24,590,967.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,550,235,125.35</b>	<b>1,427,403,850.08</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,550,235,125.35</b>	<b>1,427,403,850.08</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>76,994,840.25</b>	<b>48,894,267.78</b>
Авто тээврийн хэрэгсэл	130,000,000.00	130,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(66,805,555.72)	(88,472,222.44)
Машин, тоног төхөөрөмж	46,849,658.00	27,058,400.00
Хуримтлагдсан элэгдэл	(38,675,474.38)	(24,392,192.29)
Тавилга, аж ахуйн эд хогшил	9,259,300.00	9,259,300.00
Хуримтлагдсан элэгдэл	(4,270,027.65)	(5,195,574.49)
Номын фонд	636,940.00	636,940.00
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,473,240,285.10</b>	<b>1,378,509,582.30</b>
Програм хангамж	1,193,100.00	1,193,100.00
Хасагдуулга	(1,193,100.00)	(1,193,100.00)
Бусад биет бус хөрөнгө	1,641,675,903.20	1,641,675,903.20
Хасагдуулга	(168,435,618.10)	(263,166,320.90)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

	1,577,106,460.36	1,453,165,724.59
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>(0.00)</b>	<b>(0.00)</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>(0.00)</b>	<b>(0.00)</b>
<b>Өглөг</b>	<b>(0.00)</b>	<b>(0.00)</b>
Ажиллагчидтай холбогдсон өглөг	(0.00)	(0.00)
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,577,106,460.36</b>	<b>1,453,165,724.59</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,577,106,460.36</b>	<b>1,453,165,724.59</b>
<b>Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан</b>	<b>320,863,673.00</b>	<b>320,863,673.00</b>
Өмч: -Төрийн өмч	320,863,673.00	320,863,673.00
Хуримтлагдсан үр дүн	1,256,242,787.36	1,132,302,051.59
Өмнөх үеийн үр дүн	1,256,242,787.36	1,256,242,787.36
Тайлант үеийн үр дүн	-	(123,940,735.77)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,577,106,460.36</b>	<b>1,453,165,724.59</b>




#### 4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>234,424,400.00</b>	<b>205,183,500.00</b>
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>234,424,400.00</b>	<b>205,183,500.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>234,424,400.00</b>	<b>205,183,500.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	234,424,400.00	205,183,500.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>359,928,023.17</b>	<b>329,124,235.77</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>351,841,147.55</b>	<b>322,150,079.66</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>351,841,147.55</b>	<b>322,150,079.66</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>109,746,558.00</b>	<b>111,036,539.00</b>
Цалин	109,746,558.00	111,036,539.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,117,049.38</b>	<b>12,710,621.33</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	7,722,579.06	8,138,977.21
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	882,580.46	1,162,711.03
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,097,465.58	909,048.82
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	219,493.12	227,262.21
Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,194,931.16	2,272,622.06
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,745,000.00</b>	<b>16,385,000.00</b>
Байрны түрээс	26,745,000.00	16,385,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,450,732.00</b>	<b>9,667,570.50</b>
Бичиг хэргийн материал	989,430.00	1,095,101.00
Тээвэр, шатахууны зардал	6,209,682.00	8,099,469.50
Шуудан холбоо интернетийн төлбөр	837,120.00	174,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	414,500.00	299,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,496,600.00</b>	<b>2,135,300.00</b>
Урсгал засвар	2,496,600.00	2,135,300.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>19,850,195.00</b>	<b>9,387,776.56</b>
Гадаад томилолтын зардал	17,690,100.00	-
Дотоод томилолтын зардал	1,372,595.00	9,387,776.56
Зочин төлөөлөгч хүлээн авах	787,500.00	-
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>46,897,567.00</b>	<b>37,995,997.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,999,667.00	35,268,197.00



Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	990,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	193,500.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	52,000.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,494,000.00	1,482,900.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,400.00	9,400.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>125,537,446.17</b>	<b>122,831,275.27</b>
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,537,446.17	122,831,275.27
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,086,875.62</b>	<b>6,974,156.11</b>
Бусад урсгал шилжүүлэг		- 2,187,000.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		- 2,187,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,086,875.62	4,787,156.11
Төвлөрүүлэх шилжүүлэг	8,086,875.62	4,787,156.11
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>(125,503,623.17)</b>	<b>(123,940,735.77)</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>(125,503,623.17)</b>	<b>(123,940,735.77)</b>



### 4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>	<b>320,863,673.00</b>		<b>1,381,746,410.53</b>	<b>1,702,610,083.53</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>320,863,673.00</b>		<b>1,381,746,410.53</b>	<b>1,702,610,083.53</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(125,503,623.17)	(125,503,623.17)
<b>2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>320,863,673.00</b>		<b>1,256,242,787.36</b>	<b>1,577,106,460.36</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>320,863,673.00</b>		<b>1,256,242,787.36</b>	<b>1,577,106,460.36</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(123,940,735.77)	(123,940,735.77)
<b>2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>320,863,673.00</b>		<b>1,132,302,051.59</b>	<b>1,453,165,724.59</b>





#### 4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан


Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>243,878,196.21</b>	<b>205,183,500.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,700,328.21</b>	-
Нийтлэг татварын бус орлого	5,700,328.21	-
Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,700,328.21	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,700,328.21	-
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>238,177,868.00</b>	<b>205,183,500.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>234,424,400.00</b>	<b>205,183,500.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	234,424,400.00	205,183,500.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,753,468.00	-
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,753,468.00	-
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>243,663,696.21</b>	<b>205,183,500.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>243,663,696.21</b>	<b>205,183,500.00</b>
<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>235,576,820.59</b>	<b>198,209,343.89</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>113,500,026.00</b>	<b>111,036,539.00</b>
Үндсэн цалин	113,500,026.00	111,036,539.00
<b>Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,117,049.38</b>	<b>12,710,621.33</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	7,722,579.06	8,138,977.21
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	882,580.46	1,162,711.03
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,097,465.58	909,048.82
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	219,493.12	227,262.21
Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,194,931.16	2,272,622.06
<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,745,000.00</b>	<b>16,385,000.00</b>
Байрны түрээс	26,745,000.00	16,385,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,166,050.00</b>	<b>9,317,200.00</b>
Бичиг хэрэг	989,430.00	1,319,400.00
Тээвэр, шатахуун	7,665,000.00	7,524,800.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	837,120.00	174,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	674,500.00	299,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,496,600.00</b>	<b>2,135,300.00</b>
Урсгал засвар	2,496,600.00	2,135,300.00

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,954,200.00</b>	<b>8,628,686.56</b>
Гадаад албан томилолт	17,690,100.00	-
Дотоод албан томилолт	264,100.00	8,628,686.56
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>46,897,567.00</b>	<b>37,995,997.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	43,999,667.00	35,268,197.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	990,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	193,500.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	52,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,494,000.00	1,482,900.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,400.00	9,400.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,700,328.21</b>	<b>-</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	5,700,328.21	-
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,086,875.62</b>	<b>6,974,156.11</b>
Бусад урсгал шилжүүлэг	-	2,187,000.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	2,187,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,086,875.62	4,787,156.11
Төвлөрүүлэх шилжүүлэг	8,086,875.62	4,787,156.11
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>214,500.00</b>	<b>-</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>214,500.00</b>	<b>-</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>214,500.00</b>	<b>-</b>
Дотоод эх үүсвэрээр	214,500.00	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/	214,500.00	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(214,500.00)</b>	<b>-</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(0.00)</b>	<b>-</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>205,183,500.00</b>	<b>200,396,343.89</b>	<b>4,787,156.11</b>	<b>97.67</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>205,183,500.00</b>	<b>200,396,343.89</b>	<b>4,787,156.11</b>	<b>97.67</b>
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>201,583,500.00</b>	<b>198,209,343.89</b>	<b>3,374,156.11</b>	<b>98.33</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>113,406,300.00</b>	<b>111,036,539.00</b>	<b>2,369,761.00</b>	<b>97.91</b>
Үндсэн цалин	113,406,300.00	111,036,539.00	2,369,761.00	97.91
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,870,500.00</b>	<b>12,710,621.33</b>	<b>159,878.67</b>	<b>98.76</b>
Тэтгэврийн даатгал	8,190,370.40	8,138,977.21	51,393.19	99.37
Тэтгэмжийн даатгал	1,170,032.40	1,162,711.03	7,321.37	99.37
ҮОМШӨ ний даатгал	935,997.20	909,048.82	26,948.38	97.12
Ажилгүйдлийн даатгал	234,035.20	227,262.21	6,772.99	97.11
Эрүүл мэндийн даатгал	2,340,064.80	2,272,622.06	67,442.74	97.12
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,424,000.00</b>	<b>16,385,000.00</b>	<b>39,000.00</b>	<b>99.76</b>
Байрны түрээс	16,424,000.00	16,385,000.00	39,000.00	99.76
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,317,200.00</b>	<b>9,317,200.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
Бичиг хэрэг	576,300.00	1,319,400.00	(743,100.00)	228.94
Тээвэр (шатахуун)	6,917,100.00	7,524,800.00	(607,700.00)	108.79
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	446,800.00	174,000.00	272,800.00	38.94
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,377,000.00	299,000.00	1,078,000.00	21.71
<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>2,135,300.00</b>	<b>2,135,300.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
Урсгал засвар	2,135,300.00	2,135,300.00	-	100.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,634,000.00</b>	<b>8,628,686.56</b>	<b>5,313.44</b>	<b>99.94</b>
Дотоод албан томилолт	8,634,000.00	8,628,686.56	5,313.44	99.94
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>38,796,200.00</b>	<b>37,995,997.00</b>	<b>800,203.00</b>	<b>97.94</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,650,000.00	35,268,197.00	381,803.00	98.93
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	990,000.00	990,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	396,000.00	193,500.00	202,500.00	48.86
Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	52,000.00	146,000.00	26.26
Мэдээллийн технологийн зардал	1,485,000.00	1,482,900.00	2,100.00	99.86
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	77,200.00	9,400.00	67,800.00	12.18
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,600,000.00</b>	<b>2,187,000.00</b>	<b>1,413,000.00</b>	<b>60.75</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,600,000.00</b>	<b>2,187,000.00</b>	<b>1,413,000.00</b>	<b>60.75</b>
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,600,000.00	2,187,000.00	1,413,000.00	60.75
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>205,183,500.00</b>	<b>200,396,343.89</b>	<b>4,787,156.11</b>	<b>97.67</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>205,183,500.00</b>	<b>200,396,343.89</b>	<b>4,787,156.11</b>	<b>97.67</b>
Улсын төсвөөс санхүүжих	205,183,500.00	200,396,343.89	4,787,156.11	97.67
Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-

Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргааны 2017 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>12.00</b>	<b>10.00</b>	<b>2.00</b>	<b>83.33</b>
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	10.00	8.00	2.00	80.00
Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.00

